

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Барилга ХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат байгууллагын тайлан, оны үйл ажиллагааны үр дүн болон ирэх оны үйл ажиллагааны чиглэлийн талаархи тайлангаа уншиж танилцуулав. Тайланг хавсаргасан болно.

Л.Шагдаррагчаа: Санал, асуулт байна уу?

Г.Буд: Тасганы овооны барилгыг барихдаа инженерийн маш нарийн шийдэлтэй байх ёстой. Мөн Украин, ОХУ-ын дайны дараа Украиныг сэргээн босгох ажил гарна. 2023 оноос хойших компанийн ирээдүйтэй холбоотой асуудал. Энэ тал дээр судалж үзэх хэрэгтэй.

Л.Шагдаррагчаа: Маш зов санал байна.

Ш.Эрдэнэбат: Цахилгаан станцын шинэчлэлтийн тендер болон 5-н толгойн станцаас гадна шинэ станц баригдах талаар яригдаж байгаа юм байна лээ. Эдгээр тендерүүдэд оролцох санаатай байна.

Л.Шагдаррагчаа: 34, 5, 6-р тогтоолуудыг уншиж танилцуулав. Батлав.

7-р тогтоолыг уншиж танилцуулав.

Ш.Үнэнбат: Хөдөлмөрийн хууль шинэчлэгдсэн холбоотой гүйцэтгэх захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах. 7-р тогтоол дээр өөрчлөлт оруулах хэрэгтэй.

Л.Шагдаррагчаа: Өөрчлөлт оруулж батлуулах. 8-р тогтоолыг уншиж танилцуулав. Батлав. Мөн 9-р тогтоолыг танилцуулав.

Саналуудын дараа гарах тогтоолын төслүүдэд санал хурааж тарааж өгсөн саналын хуудсуудыг хурааж авав. Тогтоол 3, 4, 5-ийг 100 %-ийн санал нэгтэй дэмжив. Тогтоол 6 дээр тусгасан гэрээт аудитын хөлсийг жилийн 8 сая төгрөгөөр тооцохоор тогтов. Тогтоол 6-г 100 %-ийн санал нэгтэй батлав. Тогтоол 7 “2022 оны үндсэн үзүүлэлтийг батлах тухай”, тогтоол 8 “Ногдол ашгийн хуваарилалтын тухай”, тогтоол 9 “Компанийн удирдлагыг сонгох тухай”-ийг 100 %-ын саналтай дэмжигдлээ.

Өөр санал гарсангүй, хурал 15.30 цагт дуусав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Л.ШАГДАГТАГЧАА

Б.АРИУНТУЯА

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04-р сарын 14

Улаанбаатар хот

“Барилга” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлыг /цаашид ХЭХ гэх/ 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 14.00 цагаас танхимаар болон онлайнаар ТУЗ-ын нарийн бичгийн дарга хурлын ирц танилцуулснаар 14.00 цагт 40392 хувьцаа эзэмшдэг гишүүд оролцсоноор 99,3 хувийн ирцтэй эхлэв. Хуралд хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ын хараат бус гишүүд оролцов.

Zoom/Meeting ID: 932 050 1054, Passcode: 99053510/ ашиглан хийсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ын дарга Л.Шагдаррагчаа нээж хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, ТУЗ-с гаргасан тогтоол, хурлын дэгийг танилцуулав. Дэгийг 100 хувь батлав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэргүүлэгчээр Г.Буд, Л.Шагдаррагчаа, Ш.Ариунбат нарыг томилов. Мөн тооллогын комиссыг Б.Энхболд, Б.Батцагаан, С.Тунгалаг нарын бүрэлдэхүүнтэй сонголоо.

Хэлэлцэх асуудлууд:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн /ТУЗ/ тайлан, дүгнэлт – 10 минут
“Барилга” ХК-ийн ерөнхийлөгч, ТУЗ-ын дарга Л.Шагдаррагчаа
2. Компанийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан, гэрээт аудитын мэдээлэл/дүгнэлт – 8 минут
Ерөнхий нягтлан бодогч Э.Батсүх
3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны чиглэл, /өнгөрсөн оны/ үр дүнгийн болон ногдол ашиг хуваарилах тухай – 10 минут
“Барилга” ХК-ийн дэд ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай
5. Асуулт, хариулт хүн тус бүр 3 минут
6. Үг хэлэх, санал шүүмжлэл - хүн тус бүр 5 минут
7. Хурлаас гарах шийдвэрийн төсөл хэлэлцэхэд цаг тогтоохгүй

Хуралд оролцогсод тухай бүрт нь асуулт хариулт, санал шүүмжлэлүүдийг хэлэлцэхээр тогтов.

Барилга ХК-ийн ТУЗ-ийн дарга Л.Шагдаррагчаа ТУЗ-ын тайланг уншиж танилцуулав. Тайланг хавсаргав.

Үүний дараа Ерөнхий нягтлан бодогч Э.Батсүх 2021 оны санхүүгийн тайлан, Эс Эм Аудит ХХК-ийн аудитын дүгнэлтийг болон аудиторос өгөгдсөн зааварчилгаа, зөвлөмжүүдийг уншиж танилцуулав. Зааварчилгаа зөвлөмжүүдийн дагуу өгөгдсөн хариулт, тайлбаруудыг дурьдсан бөгөөд санхүүгийн тайланг хавсаргав.